

“Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн талаарх

**хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, саналаа ирүүлэхийг нийт гишүүддээ уриалж байна.**

Хүний эрх, эрх чөлөө, ардчилал, хөрөнгө оруулалт, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чухал баталгаа болсон шүүх эрх мэдлийн үйл ажиллагааг цаашид улам бүр боловсронгуй болгох, институтын хувьд чадавхийг нь бэхжүүлэх, хариуцлагатай, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол улсын Ерөнхийлөгч шүүх эрх мэдлийн шинэчлэлийг санаачилсан. Энэхүү шинэчлэлийн хүрээнд нэн тэргүүнд уг салбарын эрх зүйн орчинг сайжруулж, боловсронгуй шаардлага тулгарч байна.

Шүүх эрх мэдлийн шинэчлэлийн хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгчөөс санаачлан шүүхийн тогтолцоо, үйл ажиллагааг шинэчлэх зорилгоор шүүхийн багц хуулийг санаачлан УИХ-д өргөн барьсан. Шүүхийн хэрэглэж буй хуулийн шинэчлэл буюу гол хууль болох байцаан шийтгэх хуулиуд нь шүүхийн шинэтгэлтэй хамт боловсронгуй болгосноор шүүх эрх мэдлийн шинэчлэл цогц байдлаар хэрэгжих үндэс бүрдэнэ. Түүнчлэн, Монгол улс хүний эрхийг дээдэлсэн, ардчилсан орны хувьд хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, Үндсэн хуулийн зарчмыг хэрэгжүүлэхийн тулд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг боловсронгуй болгох нь чухал юм.

Иймээс шүүх эрх мэдлийн шинэчлэлийн хүрээнд Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулан боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын 2011.12.28-ны 270 тоот захирамжаар байгуулсан “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажилласан Шүүгчид /эрүүгийн сургагч багш/ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн үзэл баримтлалыг үндэслэн **Шүүхийн шатны үйл ажиллагаатай холбогдох хэсэгт** дараахь нэмэлт өөрчлөлт оруулах саналыг гаргаж, та бүхнээр хэлэлцүүлж байна.

Гишүүд та бүхэн бидний гаргасан саналыг судалж, ЭБШХ-д нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн өөрсдийн санал, дүгнэлтээ 2012 оны 3 дугаар сард багтаан Шүүгчдийн холбоонд ирүүлнэ үү. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг эцсийн байдлаар боловсруулахад шүүгч-гишүүн бүрийн оролцоо, санал дүгнэлт чухал байх болно.

“Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд өгөх саналыг энд дарж татан авна уу. Уг төсөлтэй холбоотой саналаа салбар хороод тус бүр хэлэлцэн Холбооны [www.judge.mn](http://www.judge.mn) веб сайтад Гишүүний эрхээр нэвтрэн орж, **Хэлэлцүүлэг** гэсэн хэсэгт шинээр явагдаж буй “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэтгэл” сэдэвт хэлэлцүүлэгт оруулна үү.

1	Холбогдох ЭБШХ-ийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулах санал	Тайлбар, үндэслэл, ач холбогдол
1	<p><b>219 дүгээр зүйл. Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх</b></p> <p>219.1. Прокурор яллагдагчаар татах тогтоолыг батлах буюу яллах дүгнэлт үйлдэн, хэргийг харъяаллын дагуу шүүхэд шилжүүлж, энэ тухай яллагдагчид мэдэгдэнэ.</p> <p>215 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос гаргах шийдвэр</p> <p>215.2.1. хөнгөн гэмт хэрэгт яллагдагчаар татсан тогтоолыг баталж, хэргийг шүүхэд шилжүүлэх;</p> <p>215.2.2. хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлэх;</p>	<p>219.1. Прокурор <u>яллах дүгнэлт</u> үйлдэн, хэргийг харъяаллын дагуу шүүхэд шилжүүлж, энэ тухай яллагдагчид мэдэгдэнэ. дугаар зүйл.</p> <p>Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос гаргах шийдвэр</p> <p>215.2.1, 215.2.2. Яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлэх;</p>	<p>1.Прокурор Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийг шүүхэд шилжүүлэхдээ 2002 оноос өмнөх ЭБШХ-д хэрэгжиж байсан бүх хэрэгт яллах дүгнэлт үйлдэх заалтыг сэргээх, Энэ нь шүүх хуралдаанаас өмнө талууд шүүхэд хэргийн онол буюу яллагдагчийн гэм буруугийн талаар баримтлах байр сууриа илэрхийлэх мэтгэлцэх зарчимд нийцнэ.</p> <p>2.Яллах дүгнэлтийг ЭБШХ-ийн 218 дугаар зүйлд нийцүүлэн үйлдэхдээ зөвхөн нотлох баримтын эх сурвалж, түүний агуулгыг тусгах Өнөөгийн практикт хэрэгт авагдсан нотлох баримтыг нэг бүрчлэн хуулбарлан бичиж, түүнийгээ шүүхийн хэлэлцүүлгийн эхэнд бүрэн эхээр нь уншдаг, улмаар нотлох баримт хэлэлцүүлэх болон ялын шүүмж хэлэхдээ дахин дахин танилцуулж нуршдагийг халж, мэтгэлцээний зөв практик, стандарт тогтоох,</p> <p>3. Хэрэг бүртгэлтэд хяналт тавьсан Прокуроруудын хариуцлагыг нэмэгдүүлж, талууд шүүх хуралдаанд бэлтгэлтэй оролцох нөхцөлийг хангахад чухал ач холбогдолтой.</p> <p>4 Дээрх заалттай уялдан ЭБШХ-ийн 231.2 гэх мэт зүйлүүдэд заасан “Яллагдагчаар татсан тогтоол” гэсэн заалтуудыг хассанаар шүүгдэгч нар нь яллах дүгнэлтийн хуулбарыг гардан авч, тэдэнд ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх, шүүх хуралдаанд бэлтгэлтэй оролцож өөрийгөө өмгөөлөх бодит боломж бүрдэнэ.</p>
2	<b>225 дугаар зүйл.</b>	225.1.Шүүхэд ирсэн	Шүүх хуралдаан удаа дараа хойшлогддог шалтгааныг

	<p><b>Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх</b></p> <p>225.1.Шүүхэд ирсэн хэргийн талаар шүүгч дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:</p>	<p>хэргийн талаар шүүгч дараахь шийдвэрийн аль нэгийг <u>урьдчилсан шүүх хуралдаанаар хэлэлцэж</u> гаргана:</p>	<p>судалж үзэхэд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Хурлын товын талаар талуудаас урьдчилж санал авдаггүй тул зарим оролцогчдын ажил давхцаж хуралдаанд ирэх боломжгүй болдог.</li> <li>2.Хохирогч, иргэний нэхэмжлэгч нараас шинээр гаргах иргэний нэхэмжлэл, түүнтэй холбоотой баримт сэлт байгаа эсэх, хуралдаан эхлэхээс өмнө шинээр гаргасан нэхэмжлэл, хүсэлт, холбогдох баримтыг иргэний хариуцагч талд танилцуулах арга хэмжээ авдаггүй,</li> <li>3.Талууд гэм буруугийн талаар ямар байр суурьтай байгаа /хэргийн онол/ болон эвлэрэн хэлэлцэх боломжтой эсэхийг тодруулах ажиллагаа хийгддэггүй,</li> <li>4.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд ЭБШХ-ийг ноцтой зөрчсөн үндэслэлээр хэргийг прокурорт буцаах санал байгаа эсэхийг хуралдаан эхлэхээс өмнө талуудаас тодруулдаггүй,</li> <li>5.Шүүгдэгч, хохирогч нарын өмгөөлүүлэх эрх бодитой хангагдсан эсэх, өмгөөлөгчөө солих буюу шинээр нэмж авах хүсэлт байгаа эсэхийг тодруулдаггүй,</li> <li>6.Мэтгэлцэгч талуулын хэргийн онолтой танилцсаны дүнд шүүх хуралдаан ямар хугацаанд үргэлжлэх, дараагийн шүүх хуралдаан хэдийд эхлэх талаар оновчтой төлөвлөлт, шүүхийн менежмент хийгддэггүй.</li> </ol> <p>Жич: Шүүхийн практикт байнга тохиолддог дээрх шаардлагуудыг шийдвэрлэхийн тулд шүүх хуралдаан зайлшгүй удаа дараа хойшлогддог бөгөөд энэ талаар дэлгэрэнгүй судалгаа хийгдсэн байгаа болно.</p> <p>Дээр дурьдсан асуудлыг нэг удаагийн урьдчилсан шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэснээр шүүх хуралдаан хойшлогдох, иргэд чирэгдэж бухимдах явдал эрс багасна.</p> <p>-Бусад улс орнуудын туршлагын харгалзан үзсэн.</p>
1	<p><b>32 дугаар зүйл. Шүүх бүрэлдэхүүн</b></p> <p>32.1.Хөнгөн, хүндэвтэр</p>	<p><b>32 дугаар зүйл. Шүүх бүрэлдэхүүн</b></p> <p>32.1.Хөнгөн, хүндэвтэр,</p>	<p>1. Хүнд ангиллын гэмт хэргийг заавал 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх шаардлагагүй. Тухайлбал, АНУ-д анхан шатны журмаар бүх эрүүгийн хэргийг шүүгч дангаар шийдвэрлэдэг.</p>

	<p>хэргийг шүүгч дангаар, хүнд, онц хүнд хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр анхан шатны журмаар сум буюу сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ.</p>	<p><b>хүнд</b> хэргийг шүүгч дангаар, онц хүнд хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр анхан шатны журмаар сум буюу сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ.</p>	<p>2. Хөнгөн, хүндэвтэр, <b>хүнд</b> ангиллын хэргүүд нь ээдрээ төвөгтэйн улмаас 3 шүүгчийн бүрэлдэхүүнээр шийдвэрлэх шаардлагатай гэж үзвэл ЭБШХ-ийн 32.2-т зааснаар шүүгч энэ тухай саналаа гаргаж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шүүх бүрэлдэхүүнийг томилох боломжтой.</p> <p>3. Дээрх өөрчлөлтийг хийснээр шүүгчдийн ажлын ачаалал хөнгөрнө.</p> <p>4. Шүүгчид хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд томилогдон шүүх хуралдааны танхимд цаг алдаж суухын оронд өөрийн хүлээж авсан хэргүүдэд илүү цаг зарцуулах боломж бий болж, шүүн таслах ажлын чанарт эерэгээр нөлөөлнө.</p>
3	<p><b>233 дугаар зүйл. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхлэх хугацаа</b></p> <p>233.1. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай шүүгчийн захирамж гарсан өдрөөс эхлэн 10 хоногоос хэтрүүлэхгүйгээр хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхэлнэ.</p>	<p><b>233 дугаар зүйл. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхлэх хугацаа</b></p> <p>233.1. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай шүүгчийн захирамж гарсан өдрөөс эхлэн 15 хоногоос хэтрүүлэхгүйгээр хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхэлнэ.</p>	<p>1. Шүүх хуралдааны товыг бүтэн 2 долоо хоног буюу 15 хоногийн аль боломжтой өдрийг талуудын саналыг харгалзан сонгож зарласнаар, шүүх хуралдааны бэлтгэл ажиллагааг сайтар хангах нөхцөл бүрдэнэ.</p> <p>2. Оролцогчид бусад ажлаа төлөвлөн хуралдаанд оролцох боломж бүрдсэнээр шүүх хуралдаан хойшлох явдал эрс багасна.</p> <p>3. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг урьдчилсан шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх үед хохирогч, иргэний нэхэмжлэгч талаас шинээр гаргасан нэхэмжлэл, баримт сэлтийг хариуцагч талд танилцуулж, ИХШХШ тухай хуулийн 72.2-т заасан “Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.</p> <p>4. Хариуцагч талд гэм хорын хохирлыг бодитой нөхөн төлж, хуульд заасан хөнгөлөлтийг эдлэх, эвлэрэн хэлэлцэх</p>

			<p>нөхцөл бүрдэнэ.</p> <p>5.Давж заалдах болон хяналтын шатны шүүх ЭБШХ-ийн 309.1, 346.2-д зааснаар хэргийг хүлээн авсан өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх заалттай нэгэн адилаар анхан шатны шүүх эрүүгийн хэргийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэдэг ижил практик тогтоно.</p>
4	<p><b>235 дугаар зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах</b></p> <p>235.1.Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах болон <u>насанд хүрээгүй этгээдэд</u> холбогдох хэрэг хянан шийдвэрлэхээс бусад бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.</p>	<p><b>235 дугаар зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах</b></p> <p>235.2.Насанд хүрээгүй этгээд, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч хүсэл гаргавал шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.</p>	<p>1.Холбогдсон хэргээ шударга шүүхээр ил тод, нээлттэй буюу олон нийтийн хяналтан дор хэлэлцүүлэх нь олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхтэй холбоотой ойлголт тул шүүгдэгчийн энэ эрхийг ЭБШХ-иар хязгаарлах нь буруу.</p> <p>2. Насанд хүрээгүй этгээд, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч хүсэл гаргавал шүүх ердийн журмаар буюу ЭБШХ-ийн 228.2.5-д зааснаар хүсэлтийг хэлэлцэж, хангах боломж нээлттэй байна.</p> <p>3."7 дугаар сарын 1-ний" гэх хэрэгт холбогдсон насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэргүүдийг шүүх хуульд заасан журмын дагуу хаалттай хэлэлцэж шийдвэрлэсэн нь олон нийтийн зүгээс ихээхэн шүүмжлэл дагуулсан.</p>
	<p><b>ГУЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ Шүүх хуралдааны ерөнхий нөхцөл</b></p>	<p>Шүүгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон буюу шүүх бүрэлдэхүүн өөрчлөгдсөн тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулах тухай заалт нэмж оруулах</p>	<p>ЭБШХ-д шүүгч, шүүхээс шалтгаалж товлөгдсон шүүх хуралдаан зайлшгүй хойшлогдох явдал гардаг боловч үүнийг зохицуулсан заалт ЭБШХ-д байхгүйгээс ойлгомжгүй байдал үүсдэг тул энэ талаар хуульд нэмэлт заалт оруулах шаардлагатай.</p>
5	<p><b>312 дугаар зүйл. Давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд оролцох бусад хүмүүс</b></p>	<p>312.2. Шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан ялтныг шүүх хуралдаанд заавал оролцуулна.</p>	<p>1.Шүүхээр гэм буруугаа 2 удаа хэлэлцүүлэх, гэм бурууг нь хэлэлцэх шүүх хуралдаад биечлэн оролцож тайлбар хэлэх, өөрийгөө өмгөөлөх нь хүний салшгүй эрхийн нэг, хүний эрхийн конвенцоор хүлээн зөвшөөрсөн ойлголт тул дээрх ЭБШХ-ийн заалтыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай.</p>

	<p>312.2. Шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан ялтныг шүүх хуралдаанд оролцуулж болно.</p>		<p>2.Бусад оронд шүүгдэгчийн энэ эрхийг Үндсэн хуулийн хэмжээнд хуульчилж өгсөн, тухайлбал ХБНГУ-д шүүгдэгчийг давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцуулалгүй хэргийг шийдвэрлэх нь ЭБШХ-ийн ноцтой зөрчил бөгөөд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болдог.</p> <p>3. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т: “... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ <u>шүүх</u> ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй ...” гэж заасныг анхаарч, ЭБШХ-ийн дээрх заалтыг Үндсэн хуулийн агуулгад нийцүүлж, шүүгдэгчийн хуулиар олгогдсон эрхийг бүрэн эдлүүлэх шаардлагатай.</p> <p>4.Шүүхийн практикийг судалж үзэхэд Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд цагдан хоригдож буй этгээдийг шүүхэд хуяглан хүргэх ажиллагааг оновчтой зохицуулаагүйгээс шалтгаалан цагдан хоригдож буй ялтныг тэр болгон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцуулахгүй, түүнчлэн цагдан хорих хугацааг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэхлээ яллагдагчийн санал, хүсэлтийг биечлэн сонсохгүй байна.</p> <p>5. Цаашид энэ талаар ЭБШХ-д хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаас гадна Online хэлбэрээр хуралдаанд оролцох боломжийг судалж, Цагдан хорих 461 дүгээр ангийг Нийслэл, дүүргийн шүүхтэй мэдээллийн технологээр дамжуулан холбогдох төсөл хэрэгжүүлэх, бусад орны практик судлах шаардлагатай.</p>
9	<b>Мэтгэлцэх зарчим</b>	<b>ЭБШХ-д мэтгэлцээний стандартыг хуульчлах, эсхүл мэтгэлцээний стандарт болон нотолгооны</b>	Энэ талаар судалгаа хийж, мэтгэлцээний болон нотолгооны стандарт дүрмийг боловсруулна.

		стандарт дүрмийг тусад нь баталж хэрэгжүүлэх	
6	<p><b>248 дугаар зүйл. Шүүх хуралдаанаас хэргийг хэрэгсэхгүй болгох</b></p> <p>248.1. Дор дурдсан тохиолдолд шүүх хуралдаанаас хэргийг хэрэгсэхгүй болгоно:  248.1.1. энэ хуулийн 24.1.1-24.1.4-д заасан байдал тогтоогдвол;  248.1.2. энэ хуулийн 208.1.2, 208.1.3 - т заасан үндэслэл байвал;  248.1.3. улсын яллагч энэ хуулийн 239.4.1-д заасан үндэслэлээр яллахаас татгалзсан бол.</p>	<p>“248.1.4. ЭБШХ-ийн 25.1 болон 24.1.2-т заасан нөхцөл байдал зөвхөн анхан шат шүүх хуралдаанаас тогтоол гарахын өмнө бий болсон тохиолдолд энэхүү үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгоно” гэсэн заалт нэмэх</p>	<p>ЭБШХ-ийн 299.3-т зааснаар анхан шатны шүүхийн тогтоолыг уншиж танилцуулснаа хуулийн хүчинтэй болж шүүхийн шийдвэр хэрэгжиж эхэлдэг. Мөн ЭБШХ-ийн 326.1-д зааснаар давж заалдах шатны шүүхийн магадлалыг уншиж сонсгомогц нэн даруй заавал биелүүлэх учиртай болдог.</p> <p>Давж заалдах болон хяналтын шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэслэл бүхий гарсан эсэхэд дүгнэлт хийдэг. Гэтэл анхан шатны шүүхийн шийдвэр зөв гарсан ч гэсэн давах болон хяналтын шатны шүүхэд хэрэг хянагдах үед ЭБШХ-ийн 25.1 болон 24.1.2-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа нь хүн бүр хууль шүүхийн эрх тэгш байх зарчимд нийцэхгүй байна. Тухайлбал, хөнгөн гэмт хэргийн зарим ялтан ял завшихын тулд давж заалдах гомдол гаргаж, улмаар хуулийн дээрх заалтад хамрагдан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөж байхад бусад ялтан нь ялаа эдэлж байдаг.</p> <p>ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн судалж үзэхэд эрүүгийн хариуцлагад татах хугацааг гэмт хэрэг үйлдсэнээс хойш Эрүүгийн хэрэг үүсгэх хүртэл хугацааг хамруулан ойлгож, нэгэнт Эрүүгийн хэрэг үүсгэсэн бол цаг хугацаанаас үл хамааран хэргийг ердийн журмаар шалган шүүхээр шийдвэрлэдэг. Иймд хөнгөн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 6 сар гэснийг 1 жил хүртэл сунгаж, уг хугацааг гэмт хэрэг үйлдсэнээс хойш яллагдагчаар татах хүртэл хугацааг хамруулан ойлгож байсан өмнөх практикийг сэргээх саналтай.</p>
7	<p><b>Шүүх хуралдааны ерөнхий нөхцөл</b></p>	<p>Анхан болон давж заалдах шатны шүүх нотлох баримт цуглуулах эрхтэй</p>	<p>ЭБШХ-ийн 246 дугаар зүйлд шүүх сонсгосон ялыг хүндрүүлэх эрхтэй байх, ингэснээр хэргийг мөрдөн байцаалтад буцаах явдал хязгаарлалт хийж байгаатай холбогдуулан шүүх нотлох баримт цуглуулах эрхийг хуульчлах шаардлагатай.</p>

			<p>Одоо ЭБШХ-ийн 155, 156 дугаар зүйлд зааснаар шинжээчийн дүгнэлт гаргуулах, нэмэлт шинжилгээ хийлгэх замаар шүүхийн шатанд нотлох баримт бүрдүүлэх эрхтэй байна. Гэтэл шүүх хуралдаанд шинээр гэрч дуудаж асуух эрхтэй эсэх нь олон жил шүүхийн практикт маргаантай явж ирсэн нь хуульчид ЭБШХ-ийн 246 дугаар зүйлийг “хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд хэргийг шийдвэрлэх” гэж буруу ойлгон тайлбарлаж ирсэнтэй холбоотой.</p> <p>Иймд энэ талаарх ойлголтыг нэг мөр зөвтгөн цэгцлэхийн тулд ЭБШХ-ийн 246 дугаар зүйлийг ХБНГУ-ын шүүхийн практикт хэрэглэдэг зөв утгаар нь төсөөтэй ойлгон хуульд дээрх нэмэлт заалтыг оруулах саналтай.</p>
7	<p><b>246 дугаар зүйл. Шүүх хуралдааны ажиллагааны хэмжээ хязгаар</b></p> <p>246.2. Шүүх сонсгосон ялыг хөнгөрүүлэх эрхтэй.</p>	<p><b>246 дугаар зүйл. Шүүх хуралдааны ажиллагааны хэмжээ хязгаар</b></p> <p>246.2. Шүүх сонсгосон ялыг <u>хөнгөрүүлэх болон хүндрүүлэх</u> эрхтэй.</p>	<p>Зөвхөн ял хүндрүүлэн сонсгох үндэслэлээр хэргийг прокурорт буцааснаар цаг хугацаа алдах, хэргийн оролцогчид чирэгдэх явдал багасна.</p> <p>Ийнхүү шүүх хэргийн зүйлчлэлийг хүндрүүлснээр ЭБШХ-ийн 246.1.-д заасан “Шүүхэд хэрэг хэлэлцэх ажиллагаа нь зөвхөн шүүгдэгчийн хувьд, гагцхүү түүнийг шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор явагдана” гэсэн заалт зөрчигдөхгүй, мөн шүүгдэгчийн эрх зүйн байдал дордохгүй. Хэрэгт авагдсан нотлох баримтыг шинжлэн судлаад гарсан үр дүнг бие даан үнэлэх шүүгчийн онцгой эрхийг хуулиар хязгаарлах шаардлагагүй. Энэ талаарх ХБНГУ-ын ЭБШХ-ийн зохицуулалтыг төсөөтэй авч хэрэглэх саналтай.</p>
5	<p><b>296 дугаар зүйл. Тогтоолын тодорхойлох хэсэг</b></p> <p>296.1. Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт шүүгдэгч урьд ял шийтгүүлсэн эсэх, гэмт хэрэг үйлдсэн газар, цаг, арга, гэмт хэргийн улмаас учирсан</p>	<p><b>296 дугаар зүйл. Тогтоолын тодорхойлох хэсэг</b></p> <p>296.1. Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг дараахь бүтэцтэй байна. Үүнд: 296.1.1. Шүүгдэгчийн биеийн байцаалт /ЭБШХ-ийн 258.1-д</p>	<p>1. Шийтгэх тогтоол нь Эрүү болон ЭБШХ-д заасан шаардлагуудыг бүрэн хангасан, хууль ёсны ба үндэслэлтэй гарах нэг чухал нөхцөл нь түүний хэлбэр, бүтцийг хуульчлах, өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэрүүд нь бичиг хэргийн нэг стандарт загварт нийцсэн байх явдал гэж үзэж байна.</p> <p>2. ЭБШХ-ийн 296-р зүйлд зөвхөн шүүхийн шийдвэрт</p>



<p>хохирол, түүний хэмжээ, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, шүүхийн дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримт, шүүхээс бусад нотлох баримтыг няцаан үгүйсгэсэн үндэслэл, хариуцлагыг хөнгөрүүлэх буюу хүндрүүлж байгаа нөхцөл байдал, хэргийн заримыг хэрэгсэхгүй болгож байгаа бол түүний үндэслэл, түүнчлэн урьд сонгосон ялыг шүүхээс өөрчилсөн бол түүний үндэслэл, шүүгдэгчийг ял эдлэхээс чөлөөлсөн, хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан бол шалтгааныг тодорхойлно.</p>	<p>заасан хүрээнд/  296.1.2. Шүүхээр тогтоогдсон гэмт хэргийн үйл баримт, үүнд: гэмт хэрэг үйлдсэн газар, цаг, арга, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний хэмжээ, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл,  296.1.3. Шүүхийн дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримт, үүнд: Шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээч нарын өгсөн мэдүүлэг болон бусад нотлох баримтын агуулга,  296.1.4. Шүүхээс бусад нотлох баримтыг няцаан үгүйсгэсэн үндэслэл,  296.1.5. Шүүхээс тогтоосон хэргийн бодит байдалд хийсэн эрх зүйн дүгнэлт  296.1.6. Хэргийн заримыг хэрэгсэхгүй болгож байгаа бол түүний үндэслэл, түүнчлэн урьд сонгосон ялыг шүүхээс өөрчилсөн бол түүний үндэслэл,  296.1.7. Хариуцлагыг хөнгөрүүлэх буюу хүндрүүлж байгаа нөхцөл байдал, шүүгдэгчийг ял эдлэхээс чөлөөлсөн, хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шалтгаан,  296.1.8. Гэм хорын хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай</p>	<p>тавигдах шаардлагуудыг хуульчилж, бүтцийг оновчтой тодорхойлж өгөөгүйгээс шүүгчид тогтоолыг янз бүрээр бичих явдал гарч байна.</p> <p>3. Шүүхийн шийдвэрийн бүтэц хуульчлагдаагүйгээс зарим шүүхийн шийдвэр товч тодорхой, бүрэн дүүрэн, уншиж танилцахад ойлгомжтой, тогтоолд дурьдсан бүх асуудал хоорондоо харилцан уялдаатай байх шаардлагыг хангахгүй байдаг.</p> <p>4. Тухайлбал, ЭБШХ-ийн 296.2-т шүүх гэмт хэрэг ба гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлын талаар олж тогтоосон, шалган нягтлах боломжтой бодит байдалд эрх зүйн дүгнэлт хийх ёстой тухай заагаагүй байна.</p> <p>5. Иймд шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн бүтцийг дээрх байдлаар хуульчилж өгснөөр шүүхийн шийдвэрүүд нэг стандарт загвараар бичигдэж, уншиж танилцахад ойлгомжтой байхаас гадна шүүн таслах ажлын чанарт эерэгээр нөлөөлөх болно.</p>
---	--	---



	дуусахаас өмнө танилцуулах арга хэмжээ авна.	алилтган тооцож, давж заалдах хугацааг тоолж эхэлнэ.	гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд түүнийг гардуулснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол, эсэргүүцлийг аймаг, нийслэлийн шүүхэд гаргана” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл хэргийн оролцогчид шүүхийн тогтоол гардаж авснаас хойш 14 хоногийн дотор, харин шүүх хуралдаан хийснээс хойш 21 хоногийн дотор давж заалдах гомдол, эсэргүүцлээ боловсруулж бичих эрхтэй байхад шүүгч 7 хоногийн дотор тогтоолоо бичиж, баталгажуулан хэргийн оролцогч нарт гардуулж өгөхөөр хуульд заасан нь амьдралд нийцэхгүй, шударга биш байна. Иймд ЭБШХ-ийн 302, 304-т заасан хугацааг ижил 14 хоног болгох нь зүйтэй.  8.Зарим хэргийн оролцогч шүүхийн шийдвэрийг мэдсэн атлаа санаатайгаар гардаж авахаас зайлсхийж, шүүн таслах ажиллагаанд хүндрэл учруулдаг. Иймд орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан шүүхийн шийдвэр гардуулах ажиллагааг шуурхай болгох нь зүйтэй гэж үзсэн. Энэ талаар ХБНГУ-ын Хелсон муж улсын шүүхэд хэрэгжүүлсэн туршлагаас санаа авсан болно.
4	88 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг шийдвэрлэхэд эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээ	88.1.7. Прокурор, шүүх эд мөрийн баримт устгах тухай шийдвэрийг эд мөрийн баримтын хамт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, холбогдох баримтыг хэрэгт хавсаргана.  Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эд мөрийн баримт устгах заалт оруулах	1. Шүүх Эрүүгийн хэрэгт хураагдсан эд мөрийн баримтыг устгахыг тухайн шүүхэд байгуулагдсан “Эд мөрийн баримт устгах комисс”-т даалган шийдвэрлэж байгаа нь зохимжгүй.  Өөрөөр хэлбэл, шүүхийн албан хаагчдаас бүрдсэн “эд мөрийн баримт устгах комисс” эрүүгийн хэрэгт хураагдан эд мөрийн баримтыг ихэвчлэн уурын зууханд аваачиж шатааж байгаа нь зохимжгүй. Мөн хутга гэх мэт зэвсгийн чанартай зүйлийг хэрхэн устгах нь тодорхой биш.
8	<b>324 дүгээр зүйл. Тогтоолыг өөрчлөх</b>  324.1. Анхан шатны шүүх	<b>324 дүгээр зүйл. Тогтоолыг өөрчлөх</b>  324.1. Анхан шатны	Дээрхтэй ижил саналтай.  Анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэлгүй давж

	<p>Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, гэмт хэргийн хүнд, хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй ял оногдуулсан нь тогтоогдвол давж заалдах шатны шүүх хөнгөн ялтай хууль хэрэглэх, эсхүл ялыг хөнгөрүүлэн өөрчилж болно.</p>	<p>шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, гэмт хэргийн хүнд, хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй ял оногдуулсан нь тогтоогдвол давж заалдах шатны шүүх сонсгосон ялыг өөрчлөхөөс гадна оногдуулсан ялыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэн өөрчилж болно.</p>	<p>заалдах явдал багасна.</p>
6	<p><b>339 дүгээр зүйл. Тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх</b></p> <p>339.3.Өвчний учир ял эдлүүлэхээс чөлөөлөх, хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх, эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, гянданд эдлүүлэх ялыг хорих ангид эдлүүлэхээр солих, хорих ангид эдлэх ялыг гянданд эдлүүлэхээр солих асуудлыг уг тогтоолыг ямар шүүх гаргасныг харгалзахгүйгээр тогтоол биелүүлж байгаа газрын шүүхийн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.</p>	<p><b>339 дүгээр зүйл. Тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх</b></p> <p>339.3.Өвчний учир ял эдлүүлэхээс чөлөөлөх, хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх, эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, гянданд эдлүүлэх ялыг хорих ангид эдлүүлэхээр солих, хорих ангид эдлэх ялыг гянданд эдлүүлэхээр солих, <u>хорих ял эдлэх дэглэм өөрчлөх</u> асуудлыг уг тогтоолыг ямар шүүх гаргасныг харгалзахгүйгээр тогтоол биелүүлж байгаа газрын шүүхийн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.</p>	<p>Ялтны хорих ял эдлэх дэглэм бууруулах асуудлыг шүүхээр шийдвэрлэхэд ЭБШХ-д удирдлага болгох заалт байдаггүй тул энэ талаар ЭБШХ-ийн 339.3-т дээрх байдлаар нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.</p> <p>Шүүхийн практикт хорих ял эдлэх дэглэмийг бууруулах буюу чангаруулах асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн тухайн ялтан оногдуулсан ялын 1/2-ийг эдэлсэн эсэхийг харгалзан үзэж байна. Учир нь хорих ял эдлэх дэглэмийг өөрчлөх эсэхэд харгалзан үзэх бусад нөхцөлийг, тухайлбал үйлдсэн хэргийнх нь нийгмийн хор аюул, гэм буруугийн хэр хэмжээ, хувийн байдал гэх мэт шалгуурыг Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тодорхой зааж өгөөгүйгээс дээрх асуудал зөвхөн хорих ангийн даргын үзэмжээр шийдэгдэж байгааг өөрчлөх хэрэгтэй.</p>

Жич: Дээрх саналыг Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимд нэгтгэв.